



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 560

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Геологийн судалгаа-шинжилгээний төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, 4 нэрийн, нийт 93,070,891.00 (ерэн гурван сая далан мянга найман зуун ерэн нэг) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, "Геологийн судалгаа-шинжилгээний төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Т.Бүжинлхам нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002139
25-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"ГЕОЛОГИЙН СУДАЛГАА - ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр,марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд он	Тоо ширхэг	Явсан км гүйлт	Балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл	Худалдах доод үнэ
							(төгрөг)	
1	Ачааны автомашин /Зил 131-0002001/	16-37 УБИ	2001575536	1986/2010	1	97,624	13,000,000.00	5,000,000.00
2	Суудлын автомашин /Тоёота Ланд круйзер-100/	02-46УНВ	JT3HT05J4X00311 95	1999/2011	1	452,370	29,000,000.00	6,000,000.00
3	Суудлын автомашин /фургон/	73-60УБЛ	40413160	2004/2005	1	92,453	19,498,800.00	1,500,000.00
4	Чирэгч автомашин /Краз 258/	93-36УНЭ	594845	1987/2003	1	56,917	31,572,091.00	5,000,000.00
Нийт дүн							93,070,891.00 (ерэн гурван сая далан мянга найман зуун ерэн нэг)	17,500,000.00 (арван долоон сая таван зуун мянга)